

Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн (цаашид “хууль” гэх) 7.4-т заасныг үндэслэн тус хуулийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд татварын алба, татварын улсын байцаагчийн зүгээс баримтлах ерөнхий зарчим, үйл ажиллааны дэс дарааллыг тогтоох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Татварын алба татвар төлөгчийг бүртгэх, өөрчлөх, бүртгэлээс хасахад татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан “Татвар төлөгчийн бүртгэлийн журам”-ыг баримтлана.

Хоёр. Албан татвар төлөгчийг төрлөөр бүртгэх

2.1. Хуулийн 4.1-д тодорхойлсон албан татвар төлөгчийг “Татвар төлөгчийн бүртгэлийн журам”-ын дагуу харьяа татварын алба татвар төлөгчөөр бүртгэнэ.

2.2. Албан татвар төлөгчийн бүртгэлийн мэдээллийг өөрчлөх, шилжүүлэх, хасахдаа “Татвар төлөгчийн бүртгэлийн журам”-ыг баримтална.

2.3. Мал тооллогын үеэр мал байгаа сум, дүүргийн татварын албанд татвар төлөгчийн татварын төрлийн мэдээллийг бүртгэнэ.

2.4. Мал байгаа нутаг дэвсгэр гэдэгт мал тооллогын үед мал байгаа сум, дүүргийн нутаг дэвсгэрийг ойлгоно.

2.5. Жил бүрийн мал тооллогын дүн мэдээний дагуу татварын төрлийн мэдээллийн өмнөх бүртгэлтэй харьяа татварын албаас хасаж, өөрчлөгдсөн татварын албаар татварын төрлийн мэдээллийг дахин бүртгэнэ.

2.6. Мал тооллогын дүн мэдээг Статистикийн үндэсний хорооноос хүлээн авч “Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэнэ.

2.7. Малын бүртгэл, хорогдлын мэдээг Малын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас хүлээн авч “Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэнэ.

Гурав. Албан татвар ногдуулах

3.1. Харьяа татварын албад жил бүрийн мал тооллогын дүн мэдээг Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд баталгаажуулах ажлыг зохион байгуулна.

3.2. Мал тооллогын дүн мэдээг баталгаажуулах ажлыг Цахим татварын системийг ашиглан жил бүрийн нэгдүгээр сард хийж гүйцэтгэнэ.

3.3. Хуулийн 5.1-д заасан албан татвар төлөгчийн өмчилж буй малын тоо толгойг тодорхойлоход хуулийн 5.2-т заасны дагуу өмнөх жилийн эцсийн мал тооллогын дүн мэдээг ашиглаж албан татварыг ногдуулна.

3.4. Харьяа сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоосон албан татварын хэмжээний дагуу Татварын удирдлагын нэгдсэн системийг ашиглаж, тооцооллыг хийн, ногдлыг 2 тэнцүү хувааж, жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдөр үүсгэнэ.

3.5. Гамшгийн улмаас мал нь хорогдсон бол Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу татвар төлөгч нотлох баримтыг харьяа татварын албанд хүргүүлснээр тухайн жилийн албан татвар ногдуулах малын тооноос хасч татварын ногдлыг засварлана.

Дөрөв. Төсөвт төлөх

5.1. Албан татвар төлөгч хуулийн 7.1-д заасан хугацаанд албан татвараа Татварын удирдлагын нэгдсэн системээс үүссэн нэхэмжлэхийн дагуу төлнө.

5.2. Албан татвар төлөгч нь үүссэн ногдлын дагуу тухайн жилийн албан татварыг төлөх эцсийн хугацаанаас өмнө урьдчилан төлж болно.

5.3. Сум, дүүргийн татварын улсын байцаагч татвар хураах ажлыг хэрэгжүүлнэ.

5.4. Татвар төлөгч хугацаандаа татвараа төлөөгүй бол Татварын ерөнхий хуулийн 55 дугаар зүйл Татварын өр хураах үйл ажиллагааг эхлүүлнэ.

Зургаа. Тайлагнах

6.1 Албан татвар төлөгч Татварын ерөнхий газрын даргын баталсан маягтын дагуу татварын тайланг тухайн жилийн 12 дугаар сарын 15-ний өдрийн дотор тайлагнана.

6.2 Тухайн жилийн тайланг өмнөх жилийн эцэст мал тоолуулсан нутаг дэвсгэрийн харьяа татварын албанд цахим тайлангийн системээр дамжуулан хүргүүлнэ.